

СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС



**СҮХБААТАР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2024 он

АГУУЛГА

- 1. НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**
- 2. НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- 3. БИЧИГ ХЭРЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 4. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**
- 5. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**
- 6. АРХИВЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР**
- 7. ЭД ХӨРӨНГӨ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 8. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 9. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 10. САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**
- 11. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР**

НЭГ. НЭГЖИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тус хэлтэс нь өөрийн үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газар, аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, аймгийн Засаг даргаас Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгуулсан гэрээ, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай хэлтсийн даргын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаанд хамаарах багц хуулиуд, холбогдох тогтоол шийдвэр, журмуудын хэрэгжилтийг хангахад гол анхаарлаа чиглүүлэн ажиллалаа.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Аргачлал загвар батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг үндэслэн “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу төлөвлөгөөний төслийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан, арга хэмжээний шалгуур үзүүлэлт бүрийг тодорхой хугацаанд биелэгдэхээр төлөвлөн боловсруулж, 2000 тэмдэгтэд багтаан товч тодорхой, бодитой, үг үсгийн алдааг хянан тогтоосон хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж батлуулсан.

2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө нь 7 зорилт, 28 арга хэмжээ 44 ажил үйлчилгээний хүрээнд батлагдан, хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс тасаг нэгжүүд, цаашлаад тасаг нэгжээс улсын бүртгэгч нартай төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэлтсийн даргатай байгуулан гүйцэтгэлд хяналт тавин ажиллав.

ХОЁР. НЭГЖИЙН ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус хэлтэс Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, цахим үйлчилгээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд гадаад паспорт захиалах 24/7 цахим машиныг Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сум Бичигт боомтын байранд 2024.04.30 өдөр байршуулан үйлчилгээ үзүүлж байна.

УБЕГ-ын тамгын газрын дэмжлэгээр 9,595.000 төгрөгийн оффисын тавилгыг шийдүүлж, ажилтан албан хаагч нарын ажиллах нөхцөл ажлын байрны өрөө тасалгааны тохижилтыг сайжруулаад байна.

УБЕГ-ын даргын 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 1/13356 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Бичигт боомтод байрлуулсан байсан үндэсний энгийн гадаад паспортыг иргэн өөрөө захиалах зориулалт бүхий цахим машиныг тогтмол хяналт тавих, хариуцах албан хаагчгүй болох эрсдэл бий болох нөхцөл байдлын улмаас хэлтсийн байранд

шилжүүлэн байршуулж, 24/7 үйлчилгээг аймгийн иргэдэд хүргэн ажиллаж байна. Үндэсний энгийн гадаад паспортыг иргэн өөрөө захиалах зориулалт бүхий цахим машинаар хэрхэн гадаад паспортыг иргэд хүссэн цагтаа хэлтсийн байранд ирж захиалах талаар мэдээ, мэдээлэл, шторк болон аймгийн BBS телевизээр мэдээлэл хүргэн ажилласан бөгөөд аймгийн хамгийн олон хэрэглэгчтэй Facebook-ийн групп чатаар мөн мэдээллийг хүргэсэн.



Зураг:1 24/7 үйлчилгээний цэгт байршуулсан цахим машин

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 484 дугаартай Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, балансаас балансад шилжүүлэх тухай тогтоолоор “Засгийн газрын авто бааз” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байсан хөрөнгө болох Lexus 570 маркын саарал өнгөтэй, туулах чадвар бүхий авто машиныг тус хэлтсийн албан хэрэгцээнд зориулан шилжүүлсэн болно.



Зураг 2: Хэлтэсийн албан хэрэгцээний авто машин

ГУРАВ. БИЧИГ ХЭРЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Архив албан хэрэг хөтлөлтийн өдөр тутмын үйл ажиллагаанд Архивын ерөнхий газраас баталсан Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар болон УБЕГ-ын даргын 2024 оны 04 дүгээр сарын 26-ны А/63 тоот тушаалаар батлагдсан “Улсын бүртгэлийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг мөрдлөг болгон ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар аж ахуй нэгж байгууллагаас нийт 516 бичгийг хүлээн авч иргэд хууль хяналтын байгууллага руу 446 бичгийг хүргүүлсэн байна. Ирсэн 516 албан бичгээс хариу ирүүлэх шаардлагатай 258 бичгэнд хяналтын карт хөтлөн хяналт тавьж хариуг хүргүүлсэн байна. Албан хэрэг хөтлөлтийн Edoc программд ирсэн, явсан бичиг болон хариутай бичиг, өргөдөл гомдлыг тухай бүр бүртгэж хэвшсэн.

Тус хэлтсийн бичиг хэргийн ажилтан нь иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлыг хариуцан авч бүртгэн хөтөлж холбогдох албан тушаалтанд хэлтсийн даргаар цохолт хийлгэн хуулийн хугацаанд хариу өгч шийдвэрлүүлэн ажиллаж байна

2024 оны байдлаар хэлтэст нийт 16 өргөдөл бүртгэгдэж үүнээс бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 13, албан хаагчаас тэтгэмжтэй холбоотой 1, хавсран гүйцэтгэхтэй холбоотой 2 өргөдлийг тус тус хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

2024 оны байдлаар хэлтсийн даргын боловсон хүчинтэй холбоотой 25, үндсэн үйл ажиллагаатай холбоотой 14 тушаал, хэлтсийн хамт олны хурлыг 13 удаа хуралдан тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан.

Үнэт цаас ашиглалтанд албан хаагчдад шаардах хуудас болон хэлтсийн дарга, нягтлан бодогчийн цохолтоор олгож хэвшсэн. Сар бүрийн үнэт цаасны тайланг гарган үлдэгдэл үнэт цаастай тулган нягтлан бодогчид өгч байна.

Хэлтсийн албан хаагчдад УБЕГ-ын даргын хөдөлмөрийн дотоод журмын нэгдүгээр хавсралтын дагуу чөлөөг чөлөөний хуудсаар олгож хэлтсийн даргаар баталгаажуулан ажиллаж байна. 2024 оны байдлаар 23 албан хаагч чөлөө авч журмын дагуу чөлөөг олгосон байна.

Удирдлага зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2024 оны 1 дүгээр улиралд багтаан “Баримт нягтлан шалгах комисс”-ыг шинээр байгуулж хурлаа хийж 2024 онд Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг батлуулсан. Дээрх үйл ажиллагаатай холбоотой 2024 онд байгууллагын архивт баримт хүлээн авах жагсаалтыг албан хаагчдад хүргүүлж дараа оны 1 дүгээр улиралд багтаан архивт авах төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.

2024 онд Архивын улсын үзлэг болохтой холбогдуулан аймгийн архивын тасгаас 2024.11.16-ны өдөр хэлтсийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалт, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд зөвлөн туслах хяналт шалгалтыг хийж газар дээр нь ирж танилцан зөвлөмж чиглэл авч ажилласан болно.

Тус хэлтсийн архив, албан хэрэг хөтлөлтийн (EDOC) систем дээр 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс тус оны 11 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд ирсэн бичгийн шийдвэрлэлтийн мэдээнд гарсан зөрчилд тайлбар ирүүлэх тухай УБЕГ-ын Тамгын газрын дарга Д.Даваанямаас 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 2/13887 дугаартай ирүүлсэн албан бичигтэй танилцлаа.

Тус хэлтэс нь 2024 оны 01 дүгээр 01-ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийг дуусталх хугацаанд Edoc албан хэрэг хөтлөлтийн программд хариугүй бичгийн хаалтын хувь 99,38, нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт 98,2 хувьтай үнэлэгдсэн байна.

ДӨРӨВ. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

УБЕГ-ын 2024 оны сургалтын төлөвлөгөө батлагдсаны дагуу хэлтсийн сургалтын төлөвлөгөөг гаргаж ажиллалаа.

Улсын бүртгэгч нарыг мэргэжил арга зүйгээр хангах, хууль, дүрэм журмыг биелүүлэн ажиллах, ажлын байрны эрсдлээс хамгаалах талаар дараах сургалтуудыг өөрсдийн дотоод нөөц боломжийг ашиглан Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид танхимаар, сумдын улсын бүртгэгчид цахим хэлбэрээр хамрууллаа.

1. 2024.01.10-нд Иргэдээс төрийн байгууллага, албан байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээ боловсруулах талаар засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан цахим сургалт
2. 2024.01.24-нд Сүхбаатар аймгийн төрийн архивын тасгаас “албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, хадгаламжийн нэгж бүрдүүлэх буюу цаасан суурьт баримтыг үдэж цэгцлэх” аргазүйн талаар заавар зөвөлгөө өгч хэлтсийн байранд сургалт зохион байгуулсан. Уг сургалтанд нийт 8-н албан хаагч хамрагдсан.



3. 2024.01.25-нд МУИХ-ын сонгуулийн тухай хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар чиглэл өгөх цахим сургалт
4. 2024.01.26-нд “Сөрөг мэдээлэл, сөрөг зүйлээс өөрийгөө хамгаалахуй” цахим сургалт
5. 2024.01.26-нд “Дөрвөлж ОНӨҮГ”-аас зохион байгуулсан танилцуулга сургалтанд хэлтсийн төвийн албан хаагчид бүрэн хамрагдсан.



6. 2024.02.13-нд Сүхбаатар аймаг дахь Тагнуулын хэлтэстэй хамтран мэдээллийн аюулгүй байдал, нууц хамгаалах талаарх сургалт

7. 2024.02.20-нд Хүний эрхийн үндэсний комиссын Сүхбаатар аймаг дахь салбартай хамтран нийт албан хаагчдад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн талаар мэдээлэл хийсэн.
8. 2024.02.29-нд авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан цахим сургалтанд хэлтсийн дарга, иргэний бүртгэлийн тасгийн дарга, ЭХЭУБ-ийн тасгийн дарга, хяналтын улсын байцаагч хамрагдсан.
9. 2024.03.14-нд “Ажлын байран дахь хоол зүйн зохистой хэрэглээ, эрүүл амьдралын зөв дадал зуршил” сэдэвт цахим сургалт




10. 2024.03.22-нд “МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, холбогдох журам танилцуулах” цахим сургалт
11. 2024.03.29-нд “МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, холбогдох журам танилцуулах” цахим сургалт
12. 2024.04.01-нд “иргэний улсын бүртгэлийн эх нотлохыг баримтжуулахад анхаарах асуудал” сэдэвт цахим сургалт
13. 2024.04.04-нд “сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрөлийг сааруулах” сэдэвт цахим сургалт
14. 2024.04.12-нд “гэр бүлийн хүчирхийлэл” сэдэвт танхимийн сургалтыг Сүхбаатар аймгийн цагдаагийн газартай хамтран зохион байгуулсан.



15. 2024.04.15-нд Хаан банктай хамтран хэлтсийн болон сумдын албан хаагчидад хадгаламж хуримтлал хэрхэн үүсгэх талаар сургалт
16. 2024.04.17-нд “Нас барсны бүртгэл” хөтлөх цахим сургалт
17. 2024.04.18-нд “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ” сэдэвт цахим сургалт
18. 2024.04.19-нд цахим хөгжлийн яамнаас зохион байгуулсан “Цахимд хэвшье” сэдэвт сургалт



19. 2024.04.26-нд Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч нарт зориулсан цахим сургалт
20. 2024.05.01-нд аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “хуульчийн про боно өдөр” өдөрлөгт оролцон иргэдэд мэдээ мэдээлэл өгч ажиллалаа.



Зураг: хуульчийн про боно өдөрлөг

21. 2024.05.06-нд Хоршооны улсын бүртгэлийн асуудлаар цахим сургалтанд сумын улсын бүртгэгч нар бүрэн хамрагдсан.



22. 2024.05.16-нд төрийн албан хаагчийн 7:4:10 цахим сургалт

23. 2024.05.29-нд “Улсын бүртгэлийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам” сэдэвт цахим сургалтанд хэлтсийн бүх албан хаагчид бүрэн хамрагдсан.

24. 2024.05.29-нд “Баримт бичгийн эргэлтийг тооцох” сэдэвт сургалтанд бичиг хэрэг болон архивч нар хамрагдсан.

25. 2024.06.23-нд МУИХ-ын сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтны сургалтыг танхимаар зохион байгуулсан.



26. 2024.08.09-нд “Сумдад хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлэх” цахим сургалт
27. 2024.08.21-нд Сүхбаатар аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран терроризмтэй тэмцэх, мөнгө угаах үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч ажилласан.
28. 2024.08.22-08.23-ны хооронд Баян-Өлгий аймагт “Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээний төвлөрөлийг сааруулах-ТА10201-МОН” төслийн хүрээнд Улсын бүртгэлийн албан хаагчдын бүсчилсэн сургалтанд нь нийт 15н албан хаагчид хамрагдсан.



29. 2024.09.04-нд “тоон гарын үсэг хурууны хээгээр олгох” талаар мэдээлэл хүргэх цахим сургалт
30. 2024.09.05-нд “Сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдлэг олгох” цахим сургалт
31. 2024.09.11-нд “Найрсаг Баруун-урт” өдөрлөгийн хүрээнд Сэтгэл зүйч Г.Наранбаатарын “Тогтвортой гэр бүлийн харилцаа-Тогтвортой ажил, амьдралын үндэс” сэдэвт лекц
32. 2024.09.16-нд хэлтсийн эрэгтэй албан хаагчидад зориулсан “ Илүүдэл жингүй эрчүүд байцгаая” 3-н сарын аянг зохион байгуулсан.
33. 2024.09.19-нд “Сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдлэг олгох сургалт” цахим сургалт
34. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас СБ аймагт зохион байгуулсан 2024.09.27-нд Иргэдийг орон сууцжуулах хэлэлцүүлэгт Улсын ахлах бүртгэгч оролцсон.
35. 2024.10.02-нд Сүхбаатар аймгийн татварын хэлтэстэй хамтран татварын шинэчилсэн хуулийн талаар сургалт зохион байгуулсан.
36. 2024.10.17-нд “ХЭУБГ –аас зохион байгуулсан цахим сургалт”

37. 2024.11.11-нд Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү түүнд нөлөөлж буй хүчин зүйл” сэдэвт цахим сургалт



38. 2024.11.13-нд “Стрессгүй ажлын байр” сэдэвт цахим сургалт зохион байгуулсан

39. 2024.11.25-нд жил болгон уламжлал болгон зохион байгуулагддаг “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянд нэгдсэн. Энэ аяны хүрээнд хэлтсийн албан хаагчид болон 13-н сумын Улсын бүртгэгчид өрх гэр, ажлын байр, олон нийтийн газарт “ЯГ ОДОО жендерт суулилсан хүчирхийллийг цэглэе!” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулна.

40. 2024.12.02-нд хэлтсийн албан хаагчдийн эрэгтэй хүүхдүүдэд “Бэлэн болсон бүтээгдэхүүний хор уршиг” сэдэвт сургалтыг зохион байгуулна. Сүхбаатар аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 онд нийт 40 сургалтын 21 сургалтыг цахим хэлбэрээр 19 сургалтыг танхимаар зохион байгуулж ажилтан албан хаагчийг мэдлэг мэдээлэлээр хангаж ажиллаа.

5.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын Наймын 8.1 дэх хэсэгт зааснаар түүвэрчилсэн хяналт шалгалтыг хийж ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэл: МУИХ-ын сонгууль болон нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөгч нарыг сонгох сонгуулийн өмнөх шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогссонтой холбогдуулан 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс хойш хийгдсэн 1186 бүртгэл дээр хэлтсийн төлөвлөгөө гарган бүртгэл нэг бүрийн эх нотлох баримтыг цахим сантай тулгалт хийн бүртгэл үнэн зөв байх зарчмыг баримтлан, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалт хийж гүйцэтгэв Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 10.3, 10.4-т заасны дагуу иргэний хүсэлт, өргөдөл, бүртгэлийн дэвтэр, ИУБ-22 маягтын баруун дээд өнцөгт хянасан тухай он, сар, өдрийг бичиж, гарын үсэг зурж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажууллаа. Шалгалтаар нийт 95 зөрчил илэрсэн бөгөөд нийт илэрсэн зөрчлийн 90 зөрчийг шалгалтын явцад арилгуулаад байна. Үлдсэн 5 зөрчил нь Баруун-Урт сумын 5-р баг нь 2 хуваагдаж 5,9-р баг болсон ба ҮХЭХ-ийн гэрчилгээ нь банкны барьцаанд байгаа тул хаяг солих боломжгүй байна. Шалгалтын мөрөөр цаашид анхаарах асуудлаар ИУБ-ийн тасагтай хурал хийж бүртгэгч нэг бүрээр гарсан алдааг танилцуулан дээрх алдааг дахин давтан гаргахгүй ажиллахыг үүрэг болгосон. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоох хугацаанд хийгдсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой өргөдөл, гомдол, хүсэлт иргэн, хуулийн этгээдийн зүгээс ирээгүй болно.

Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/671 тушаалаар байгуулагдсан ИУБ-ын мэдээлэлийн санг цэгцлэх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээлэлийн санд 2 буюу түүнээс дээш бүртгэгдсэн төрсний, нас барсны бүртгэлийн аль нэг бүртгэлийг хүчингүй болгох ажил төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд нэр бүхий 4 иргэний бүртгэлийг эх нотлох баримт бичигтэй тулган шалгаж хүчингүй болгох хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг гарган ажиллаа.

Эд хөрөнгийн улсын бүртгэл: ХЭЭХЭУБ-ын тасгын даргаас 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн №2404-02 тоот дотоод албан бичгээр эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар нийт 873 бүртгэлд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн бөгөөд 38 бүртгэлд зөрчил илэрсэн байх бөгөөд Хяналтын улсын байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 20 өдрийн №27 тоот албан шаардлагыг хүргүүлж ажиллаа. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, цаашид зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчил, буруутай үйл ажиллагааг таслан зогсоох, нийтлэг гарч буй зөрчлийг тодруулан түүнд анализ дүн шинжилгээ хийх, улсын бүртгэгч нарын мэдлэг чадварыг сайжруулах, бүртгэл хөтлөх ур чадварыг нэмэгдүүлэх тал дээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэл: Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой хяналтын улсын байцаагчийн 3 дүгнэлтийг гаргасан байна.

Хуулийн этгээдийн мэдээлэлд орж буй өөрчлөлтийг хугацаанд нь бүртгүүлэх талаар ААН болон албан газруудыг мэдээ мэдээлэлээр хангаж ажиллах ажлыг зохион байгуулав. Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны тайланг хугацаанд нь авах ажлыг зохион байгуулж нийт 53 төрийн бус байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 11.7 дугаар зүйл зөрчигдөхөөс урьдчилан сэргийлж ажиллаа

Статистик болон зөрчлийн тоон мэдээ тайлагнах: Сар бүрийн статистик тоон мэдээ болон зөрчлийн мэдээг zurchliin.san@burtgrl.gov.mn хаягаар тогтоосон хугацаанд нийт 10 удаа хүргүүлэн ажиллаж байна.

Хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа: 2024 оны 11 дугаар сарын байдлаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Иргэний улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр хяналтын улсын байцаагчийн нийт 47 дүгнэлтийг гаргасан бөгөөд гаргасан бүх дүгнэлтийг хяналт шалгалт зөрчлийн нэгдсэн санд бүртгэн нотлох баримтын хамт цахимжуулан ажиллаж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаа: Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж шийтгэл оногдуулсан 298 хүн хуулийн этгээд байх бөгөөд 8,045,000 төгрөгийн торгуулийг ногдуулаад байна. Үүнийг торгууль тус бүрээр задлан авч үзвэл

- | | |
|------------------------------------|--------------------------|
| ✓ Зөрчлийн тухай хуулийн 10.2.1 | “4 хүн хуулийн этгээд “ |
| ✓ Зөрчлийн тухай хуулийн 15.23.1.1 | “ 6 хүн хуулийн этгээд ” |
| ✓ Зөрчлийн тухай хуулийн 15.24.1 | “ 234 иргэн” |
| ✓ Зөрчлийн тухай хуулийн 15.24.2 | “ 11 иргэн” |
| ✓ Зөрчлийн тухай хуулийн 15.24.4 | “ 43 иргэн” байна. |

Иргэн болон хуулийн этгээдийн зүгээс тус хэлтэст улсын бүртгэлтэй холбоотой гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч хуульд заасан хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.

ЗУРГАА. АРХИВЫН АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

ИУБ-ийн архив:

Үндсэн ажлын хувьд 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн архивын санд 76,780 хувийн хэрэг хадгалагдаж байна. Бусад аймаг нийслэлээс 200 иргэн, 150 хүүхдийн хувийн хэрэг болон биеийн давхцахгүй өгөгдлийн ИУБ-31 маягт 3128 ширхэгийг галиглан хувийн хэргийн санд байршуулсан.

ИУБ31 маягтын А талыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын иргэний бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид, иргэний

үнэмлэхний хугацаа сунгалт ИУБ31 маягтын А талыг Улсын бүртгэлийн төв архивын Иргэний баримтын архивт нэрийн үсгийн эхээр галиглан, дагалдах хуудсын хамт хүргүүлж байна.

Архивын фондоос 300 иргэний хувийн хэрэг болон журнал,хаатр-1 маягт, хаатр-11, ИУБ-11 маягтуудыг татан авч шалгаж цахимжуулж зөрчлийг арилгасан байна.

Сар болгоны 25 өдрөөр тасалбар болгон мэдээ тайлангаа тогтмол гаргаж өгдөг.

Шинээр цахим үнэмлэх авах 1999, 1979, 2008 оны **1416** ИУБ11 маягтуудыг программд шалгаж өөр аймаг, хотод ИШБ-д хамрагдсан **150** ИУБ11 маягтуудыг тухайн аймаг, хотод шилжүүлэв. Нөхөн бүртгэлээр **10** иргэний хувийн хэргийг /ИУБ11, ИУБ15/ маягтуудыг журнал хувийн хэргийн лавлагааг үндэслэн иргэний улсын бүртгэгчээр бүрдүүлэн хувийн хэрэгт байршуулсан.

Улсын бүртгэлийн салбарын үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичгийн хадгалах хугацааны жагсаалтаар хадгалах хугацаа нь дууссан хадгаламжийн нэгж буюу хуудас баримт бичгүүдийг хэлтсийн дэргэдэх комиссын хурлаар хэлэлцэж баталсан шийдвэрийн дагуу 2024 01.02-ны өдрийн А/02 тоот тушаалаар баримт бичиг нягтлан шалгах комиссын бүрэлдэхүүнтэй устгах ажлыг зохион байгуулсан.



Мөн 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн архивын нотлох баримтыг тооллогод хамруулж дуусгасан байна. Үүнд.

-Архивын санд хадгалагдаж байгаа хувийн хэргийн тоо-76,780

-Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэн (16, 25, 45 нас)-29,475

-16 наснаас доош насны хүүхдийн хувийн хэрэг (ИУБ-11 маягт)-26,853

-Тодорхойгүй санд байгаа хувийн хэрэг-750,000

-Архивын санд хадгалагдаж байгаа нас баралт-11,100 архивын санд хадгалагдаж байна.

ХЭЭХЭУБ-ийн архив:

Архивын нийт цонхыг стандартын дагуу битүүлсэн. Цаашид галын дохиолол, аваарын гэрэл, камержуулалтыг сайжруулахаар төлөвлөн ажиллаж байна.



Зураг 5. Архивын цонх битүүлэх явц

Зураг 6. Архивын цонх битүүлсний дараа

- Архивын хадгаламжийн нэгж, нягтаршуулсан шүүгээний талаарх одоогийн байдлаарх мэдээлэл судалгааг мөн цаашид авах шаардлагатай арга хэмжээ, нэмж шаардагдах нягтаршуулсан шүүгээний судалгааг тооцоолон гаргаж нэгдсэн архивын газарт санал хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/290 тушаалын хавсралтын Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журмын 4.5.1-нд заасны дагуу аймаг, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст бүртгэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг болон улсын бүртгэлд

бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг бүртгэл хийснээс хойш ажлын 1 өдөр, анхны бүртгэлийг ажлын 5 хоногийн дотор гэсэн журмыг үндэслэн улсын бүртгэгч нараас мэдүүлэг, нотлох баримт, анхны бүртгэлийг архивт хүлээн авч ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2024 оны 10 дугаар сарын 25-ний өдрийн А/15 тоот тушаалыг үндэслэн хавсралтад заасан нэр бүхий хуулийн этгээдүүдийн 29 ширхэг хүчингүй болгосон тэмдэгүүдийг устгав. Хүчингүй болгосон тэмдэгүүдийг устгахад хэлтсийн даргын тушаалаар томилогдсон комиссын гишүүд байлцаж устгах үйл ажиллагааны аюулгүй байдлыг ханган, тэмдгийг шатааж, зургаар баримтжуулсан болно.



Зураг 7. Хураан авсан тэмдэгүүдийг устгал хийх явц

Архивт хадгалагдаж байгаа татан буугдсан 74, хасагдсан хуулийн этгээд 95, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 44 хувийн хэргийг эмхэлж цэгцэлсэн.

Архивын ерөнхий газраас ирүүлсэн архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын талаархи судалгаа, саналын хамт хүргүүлсэн.

Улсын бүртгэгч нарын өдөр тутмын хөтөлсөн бүртгэлийн эх нотлох баримтыг журамд заасан хугацаанд хүлээн авч хувийн хэрэгт баяжилтыг хийдэг.

Архивт хадгалагдаж байгаа бүх хувийн хэргийн хавтсыг стандартын шаардлага хангасан цаасан хавтсаар бүрэн солив.



Зураг 8. Архивын хувийн хэргийн хавтсыг сольсон байдал (өмнөх ба дараахь)

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/290 тушаалын хавсралтын Улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг архивт хадгалах журмын 4.5.1-нд заасны дагуу аймаг, дүүрэг дэх улсын бүртгэлийн хэлтэст бүртгэгдсэн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг болон улсын бүртгэлд бүртгэгдсэн эрхийн улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийг бүртгэл хийснээс хойш ажлын 1 өдөр, анхны бүртгэлийг ажлын 5 хоногийн дотор гэсэн журмыг үндэслэн улсын бүртгэгч нараас мэдүүлэг, нотлох баримт, анхны бүртгэлийг архивт хүлээн авч ажиллалаа.

ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь 2024 онд “ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГАА”-г дэмжихэд чиглэсэн ажлуудыг төлөвлөн, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлтийг хангах ажлын хүрээнд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллалаа.

ОНЦЛОХ АЖЛУУД:

- Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тэлэх, улмаар сумдын улсын бүртгэгчдэд эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх олгогдсонтой холбоотойгоор сумдын улсын бүртгэгчдийн ур чадварыг дээшлүүлэх, тэднийг ажлын байрны сургалт, арга зүйгээр хангах, ажлын ачааллын төвлөрлийг тараахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх
- Хуульд үндэслэн бүртгэл хөтөлсөн эсэхэд хийсэн хяналт шалгалт, илэрсэн зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах
- Ажлын байр, үйлчилгээний танхимын тохижилтын ажил
- Шинэ санаа, санаачлагыг дэмжих, нэвтрүүлэх
- Шинэ-Хоршоо, Хоршооны бүртгэл
- Сонгуультай холбоотойгоор төрийн байгууллагын удирдлага өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим санд хуульд заасан хугацаанд бүртгэх, хугацаа хоцрон торгуулийн асуудал үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх
- Бүх сумдын төрийн байгууллагуудын эзэмших эрхийн газрын давхар бүртгэлийн асуудлыг цэгцлэх, мөн дахин төлөвлөлт, газар чөлөөлөлттэй холбоотой хаагдах бүртгэлүүдийг цэгцлэх.

Хэлтсийн албан хаагчид, улсын бүртгэгчдийн үйлчилгээний стандарт, хандлага, ёс зүй, ур чадварыг хэрэглэгчийн үнэлгээгээр үнэлж тогтоон, цаашид үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Цахимаар үнэлэх үнэлгээний асуумж” боловсруулан, иргэдээр үнэлгээ хийлгэх цахим холбоос болон QR code-ыг шинээр нэвтрүүлээд байна.




Цахим холбоос: <https://forms.gle/24QMhCsjYtSMMfBw5>

Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын ажлын байрыг нүүлгэн шилжүүлсэнтэй холбогдуулан өнгөрөгч оны сүүлийн хагас жилд тасгийн үйлчилгээний танхим, өрөө тасалгааг зохион байгуулан, засвар хийж шинээр гарган тохижуулсан. Улмаар энэ онд тус тасгийн хамт олон нь ажлын байр, танхимаа үйлчилгээний стандартад нийцүүлэн нэмж тохижуулах, иргэн хуулийн этгээдэд бүртгэлийн үйлчилгээг тасралтгүй хүргэж, тав тухтайгаар бүртгэлийн үйлчилгээг авах, албан хаагчдад ажиллах таатай орчинг бүрдүүлж өгөх, мэдээллийн самбартай болох, үйлчлүүлэгчийн сандал ширээг сайжруулах ажлуудыг тус тус төлөвлөөд идэвхи санаачлагатайгаар оролцож, өөрсдийн дотоод нөөц бололцоо, хүч хөдөлмөрөөр үйлчилгээний танхимаа тохижуулсаар байна.



Зураг 2. Засвар хийсний дараахь байдал



Зураг 3. Үйлчилгээний танхим тохижуулсны дараа

ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Энэ онд хэрэгжүүлсэн онцлох арга хэмжээний нэг бол Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх сумд болон улсын бүртгэгчийн тоог нэмэгдүүлэх санал хүргүүлснээр өмнө нь 2 суманд үзүүлдэг байсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг **шинээр 5** суманд хүргэж эхлээд байна. Ингэснээр сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хийлгэх 764 мэдүүлгийг хүлээн авч газар дээр нь шийдвэрлэж тэр хэмжээгээр сумдын иргэдийн цаг хугацаа, зардал мөнгийг хэмнэж, иргэд эд хөрөнгөө эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцөл хангагджээ. Сумдад 764 хүсэлтийг шийдвэрлэсэн нь хэлтэс дээр хийгддэг байсан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт үйлчилгээний 15 орчим хувьтай тэнцэж байгаа нь ажлын ачааллыг мөн тэр хэмжээгээр тэнцвэржүүлсэн байна.

Шинээр эрх олгогдсон сумдын улсын бүртгэгч нарт бүртгэл хөтлөхтэй холбоотой ажлын байрны болон онлайн сургалт, арга зүйгээр ханган, чиглэл зөвлөмжийг хүргүүлэн, ажлын байрны сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулан ажиллаа.



Зураг. Сумдын улсын бүртгэгч нарт онлайн сургалтуудыг хийлээ.

Бүх сумдын төрийн байгууллагуудын эзэмших эрхийн газрын давхар бүртгэлийн асуудлыг цэгцлэхээр Г дугаар, Э дугаар давхар олгогдсон хувийн хэргүүдийн жагсаалтыг гарган хаахаар газрын харилцаа барилга хот байгуулалтын газартай хамтран ажиллаж тодорхой арга хэмжээг авч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар бүртгэл хаах тухай 55 дүгнэлт гаргаад байна.

Мөн аймаг, сумын дахин төлөвлөлт, газар чөлөөлөлттэй холбоотойгоор хаагдах бүртгэлүүдийг цэгцлэх ажлын хүрээнд аймаг, сумын Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа хот байгуулалтын газар, аймгийн хөгжлийн бодлогын хэлтэс, иргэд хуулийн этгээдүүдтэй хамтран ажиллаж байна. 2011 оноос хойш хийгдсэн газар чөлөөлөлтөд орсон иргэдийн судалгаа, мэдээллийг цуглуулж, цахимжуулан цахим сан бүрдүүллээ. Ингэснээр газар чөлөөлөлтөд ороод бүртгэлээ хаалгаагүй байгаа иргэдийн жагсаалтыг гарган авч, энэ мэдээлэлдээ суурилан дараагийн шатанд авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлсэн үйлчилгээний тоон мэдээг нэгтгэвэл: (2024.01.01-2024.11.19 хооронд)

□ Иргэн, хуулийн этгээдээс нийт 5,960 мэдүүлгийг хурууны хээгээр хүлээн авч, шийдвэрлэсэн байна. Үүнээс сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд Асгат, Уулбаян, Халзан, Мөнххаан, Эрдэнэцагаан, Дарьганга, Баруун-урт сумдын 7 улсын бүртгэгч иргэдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэн, 764 мэдүүлэг хүлээн авч шийдвэрлээд байна. Энэ онд шинээр 5 сумын улсын бүртгэгчдэд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх олгогдсон байна. Мөн онлайн мэдүүлэг 90-г хүлээн авч шийдвэрлэсэн байна.

- Анхны бүртгэл нийт - 621
- Өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл - 871
- Барьцааны гэрээ болон бусад гэрээ – 4096
- Бүртгэлд өөрчлөлт оруулах – 151 бүртгэлийг тус тус хөтөлсөн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээнээс улс, орон нутгийн төсөвт татварын орлого 389,521,046 төгрөг, үйлчилгээний хөлс 73,682,556 төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 4,816,922 төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Иргэн, хуулийн этгээдийн хүсэлтээр үйлчилгээний танхимаар 25 лавлагаа, харин хууль хяналтын байгууллагын албан бичгээр үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрх түдгэлзүүлэх, цуцлах, сэргээхтэй холбоотой нийт 145 бүртгэл хөтөлж хариу албан бичгийг холбогдох лавлагаа, мэдээллийн хамт хууль, журмын дагуу олгоод байна.

Үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхтэй холбоотойгоор иргэн, хуулийн этгээдээс энэ хугацаанд өргөдөл гомдол 7-ыг хүлээн авч, шийдвэрлээд байна.

Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг цаг алдалгүй залруулах ажлыг зохион байгуулж хууль, журмын дагуу хяналтын улсын байцаагчтай хамтран эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэл хөтөлсөн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийснээр хяналтын улсын байцаагчийн дүгнэлт болон 2022 оны Улсын байцаагчийн 1500 дугаартай нэгдсэн дүгнэлт, нотлох баримтад үндэслэн нийт 137 зөрчлийг арилгах, цахим мэдээллийн санд холбогдох засвар өөрчлөлт оруулах, дархардсан бүртгэлийг хаах зэрэг ажлыг цаг тухайд нь шийдвэрлээд байна.

2024-01-01 өдрөөс 2024-04-10 өдрийг дуусталх хугацаанд хөтөлсөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн жагсаалтыг улсын бүртгэгч тус бүрээр гарган 4 улсын бүртгэгчийн нийт 1425 бүртгэлийн үйл ажиллагаанд хамтран хяналт шалгалт хийлгэхээр хяналтын улсын байцаагчид дотоод албан бичгээр хандсан байна. Шалгалтын явцад илэрч буй нийтлэг зөрчлүүдэд дүн шинжилгээ хийн, тухайн улсын бүртгэгчид албан шаардлага хүргүүлэн зөрчлийг арилгуулах, дахин зөрчил гаргахгүй байх, хууль журамд нийцүүлэн бүртгэл хөтлөх тал дээр онцгой анхаарал хандуулан, улсын бүртгэгч нарын мэдлэг, хөрвөн ажиллах ур чадварыг сайжруулахад чиглэгдсэн ажлын байрны анхан шатны болон давтан сургалт, арга зүйгээр ханган ажиллаж байна.

Мөн УБЕГ, ХШГ, ЭХЭУБГ, ХЭУБГ болон холбогдох бусад байгууллагаас албан бичгээр ирүүлсэн 63 чиглэл зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар болон тушаал журмыг хяналтандаа авч улсын бүртгэгч нарт тухай бүрд танилцуулан, бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн хамрагдвал зохих танхимын болон цахим сургалтуудад идэвхитэй бүрэн хамрагдсан.

Хамтын ажиллагаа, бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэнд ойртуулах зорилгоор байгууллагуудтай хамтран дараахь арга хэмжээг шинээр санаачлан зохион байгууллаа. Үүнд:

Улсын бүртгэгч Г.Оюунжаргал:

- Соёлын газартай хамтран зохион байгуулсан “Тоон гарын үсгийг ашиглан соёлын өвийг бүртгүүлцгээе” видео контентод оролцсон.
- Өдөр тутмын Зууны мэдээ сонинг байгууллагад захиалах ажлыг санаачлан, улмаар үрэгдүүлсэн гэрчилгээ, тамга болон татан буугдсан хуулийн этгээдийн зар нийтлэгдсэн сонинг иргэд хотруу захиж авчирч хугацаа алддаг, хүндрэл бэрхшээлтэй байсан асуудлыг шийдвэрлэсэн.
- Хуульчдын “Про боно өдөрлөг-2024” –д оролцож 65 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Улсын бүртгэгч Ж.Должинсүрэн:

- Тасгийн үйлчилгээний танхимын тохижилтод санаачлага гарган нэг ханыг тохижуулан засварлах ажлыг хариуцан гүйцэтгэсэн.

- Хаан банктэй хамтарсан “Тоон гарын үсэг олголтыг идэвхижүүлэх аян” – ны хүрээнд Баяндэлгэр суманд ажилласан.

Улсын бүртгэгч С.Энхбаатар:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагын ажилчидад Цагдаагийн газрын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ахлах мэргэжилтэн хошууч Сугаржаваар 2024.04.12-нд сургалт явуулсан. Байгууллагын аюулгүй байдлыг хангах чиглэлээр 7 ширхэг камер суурьлуулах ажил хийгдсэн.
- Мөн нийгмийн хариуцлагын хүрээнд байгууллагын алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг болох зорилгоор байгууллагын хашаанд ногоо тарих ажлыг санаачлан зохион байгуулсан.

Улсын ахлах бүртгэгч Ц.Мөнхчимэг:

- Мөн хэлтсийн албан хаагчид, улсын бүртгэгчдийн үйлчилгээний стандарт, хандлага, ёс зүй, ур чадварыг хэрэглэгчийн үнэлгээгээр үнэлж тогтоон, цаашид үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор “Цахимаар үнэлэх үнэлгээний асуумж” боловсруулан, иргэдээр үнэлгээ хийлгэх цахим холбоос болон QR code-ыг шинээр нэвтрүүлээд байна. Цахим холбоос: <https://forms.gle/24QMhCsjYtSMMfBw5>
- Тасгийн үйлчилгээний танхимыг тохижуулах, иргэдийн үйлчлүүлэх болон албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, ажиллах нөхцөл байдалд өөрчлөлт хийхийг зорьж тохижилтын ажлыг санаачлан, хамт олноо уриалан, өөрсдийн нөөц бололцоонд суурилан хямд зардлаар засварын ажлыг удирдан зохион байгуулж ашиглалтад оруулсан.
- Орон нутгийн BBS телевизтэй хамтран Улсын бүртгэлийн байгууллагаас Бичигт гаалийн байранд суурьлуулсан гадаад паспорт захиалгын 24/7 ухаалаг төхөөрөмжийг суурьлуулсан, ашиглалтад хүлээлгэн өгсөн талаарх мэдээллийг бэлтгэн мэдээллийн хэрэгслэлүүдээр түгээсэн.
- Орон нутгийн BBS телевизтэй хамтран хуульд заасны дагуу “Шилжилт хөдөлгөөний бүртгэл албан ёсоор хаасан тухай” мэдээллийг бэлтгэн мэдээллийн хэрэгслэлүүдээр түгээсэн.
- Тохижилт үйлчилгээний газартай хамтран тус байгууллагын үйлчилгээний ажилчдад тоон гарын үсгийг олгох ажлыг зохион байгуулсан.
- Соёлын газартай хамтран зохион байгуулсан Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, уламжлалт ёс заншлыг хүүхдэд таниулах зорилгоор бүтээгдсэн сургалтын шинэ хөтөлбөрт гэр бүлийн хамтаар оролцсон.

Баяндэлгэр сумын иргэдэд улсын бүртгэлийн 3 үйлчилгээг цогцоор нь зөөврийн төхөөрөмжийн тусламжтайгаар хүргэх өдөрлөгийн арга хэмжээг тус сумын тамгын газартай хамтран зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлаа ханган ажиллаж байна.

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Мөн онд хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээний нэг болох хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд шинээр нэвтрүүлэх, цахимжуулах зорилготой **ADB** төсөл хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор **сумдын 7 улсын бүртгэгчид** Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх олгогдсноор хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг сумандаа хүргэж эхлээд байна. Ингэснээр сумдад хуулийн этгээдийн улсын бүртгэл хийлгэх 103 хүсэлт, оноосон нэр авах 94 хүсэлтийг хүлээн авч, газар дээр нь шийдвэрлэсэн байна. Ингэснээр аймгийн хуулийн этгээдийн нийт бүртгэлийн **25 орчим хувийг** сумаас үзүүлсэн байна.

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд нийт 243 бүртгэл хөтөлсөнөөс шинээр байгуулагдсан хоршоо 191, харин хоршооны гишүүдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан 52 хоршоо байна. Улсын бүртгэгчдийн ачааллыг тэнцвэржүүлэхээр Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгаас зохион байгуулалтын арга хэмжээг авч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Г.Оюунжаргал, шинээр эрх олгогдсон сумдын улсын бүртгэгч нарт холбогдох сургалт, чиглэлийг өгч, бүртгэгчийн баталгааны тэмдэг, үнэт цаасаар хангаснаар бүртгэл хөтлөх боломжийг бүрдүүлсэн. Бусад эрх олгогдоогүй сумдын улсын бүртгэгч нар нь тухайн сумандаа томилогдон ажиллаж буй хоршооны багийн гишүүдтэй хамтран ажиллаж иргэдэд зөвлөгөө мэдээллийг өгч, бүрдүүлэх эх нотлох баримтуудыг нягтлан шалгаж, цахимаар хэлтэст ирүүлснээр бүртгэл хөтлөгдөх явцыг хурдасгаж, хамтран ажиллалаа.

Зураг. Шинэ хоршооны бүртгэлийн явц



Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон журмууд, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон хэлтэс, тасгаас ирүүлсэн чиглэл, зөвлөмжүүдийг бүртгэл хөтлөх үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2024 онд иргэн, хуулийн этгээдээс нийт-476 өргөдөл хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнээс:

Шинээр байгуулагдсан хуулийн этгээд 272 бүртгэгдсэнээс: ХХК 70, Хоршоо-191, ТББ 7, ҮЭБ 2, Хадгаламж зээлийн хоршоо 1, Төрийн байгууллага албан газар-1 тус тус бүртгэгдсэн байна.

Тус аймгийн харьяалалд 3 хуулийн этгээд шилжин ирж улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Төрийн бус байгуулагууд 2023 оны үйл ажиллагааны тайлангаа 02 сарын15 өдрийн дотор улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлэх хуулийн хүрээнд сумын бүртгэгч нартай хамтран 53 хуулийн этгээдийн тайланг авч архивлан хүлээлгэн өгсөн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018.11.01-ний өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-д заасны дагуу хуулийн этгээдийн салбарыг шинээр бүртгэх болон мэдээлэлд орсон өөрчлөлтийг тус нэгж дээр хүлээн авч бүртгэн, бүртгэлийн эх нотлох баримт бичгийг дугаарлан цахимжуулж хувийн хэргийг нь харьяалагдах нэгжийн архивт шилжүүлэн ажилласан байна. Үүнд: Шинээр байгуулагдсан Салбар төлөөлөгчийн газрын бүртгэл 8 , Салбар төлөөлөгчийн газрын бүртгэлд орсон өөрчлөлт 5 бүртгэгдсэн.

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт давхардсан тоогоор нийт 198-ыг бүртгэсэн байна.

Хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад тамга, тэмдгийн хяналтын дугаар шинээр нийт 333 -г олгож, 36 хуулийн этгээдээс тамга тэмдгийг хураан авч архивчд хүлээлгэн өгсөн.

Иргэн хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтээр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 61 лавлагаа олгосон байна. Үүнээс: Албан тоотоор 14, иргэн хуулийн этгээдэд 47 лавлагаа, 15 хуулбар олгосон.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, баримт бичгийн олголтыг 570 иргэнд хийсэн байна.

Тайлангийн хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой нэхэмжлэлтэй шүүхээр хянагдаж байгаа болон Шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй хэрэг маргаан гараагүй байна.

Иргэдэд эрх зүйн мэдлэг олгох, байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор Улсын бүртгэлийн хууль тогтоомж, мэдээ мэдээллийг олон нийтийн цахим хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлан ажилласан.

Холбогдох байгууллагын шийдвэрийг үндэслэн хориг тавих бүртгэлийг 6 хуулийн этгээдийн улсын бүртгэлд хийж харин 1 хуулийн этгээдийн бүртгэлд тавьсан хоригийг цуцласан байна.

Хууль зүйн сайдын 2018.02.13-ны өдрийн А/24 дүгээр баталсан “Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журам” –ын дагуу сар бүр хуулийн этгээдийн тоон мэдээг хугацаанд нь тогтмол гаргаж ХЭБГ-т хүргүүлэн ажилласан.

ХЭБГ-с болон ХШГ-аас ирүүлсэн чиглэл, албан даалгавар, мэдээлэл судалгааг цаг тухай бүрт нь хийж хүргүүлсэн.

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2017.12.06-ны өдрийн А/1021 дүгээр тушаалаар баталсан “Үйлчилгээний орлогын мэдээний маягт, маягт нөхөх зааврыг батлах тухай” журмын дагуу Үйлчилгээний орлогын мэдээ болон үнэт цаасны тайланг сар бүр тогтоосон хугацаанд нь гаргаж санхүүд өгч, алдаа зөрчилгүй ажилласан.

Энэ онд орон нутгийн сонгууль явагдаж улмаар засаг захиргаа, нутгийн өөрөө удирдах байгууллагууд гэх мэт төрийн байгууллагын удирдлагын мэдээлэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан тухайн өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим санд хуульд заасан хугацаанд бүртгэх, хугацаа хоцрон торгуулийн асуудал үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор арга хэмжээг авч хэрэгжүүлэх тал санаачлагатай ажиллаж байна.

ЕС. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

2024 онд Монгол улсын УИХ-ын сонгууль, Орон нутгийн ИТХ-ын сонгуулийн жилтэй холбогдуулан УБЕГ-аас баталсан “Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу дараах төлөвлөсөн ажлуудыг хуульд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд :

1. Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу аймгийн 13 сумдын ИТХ-ын хэсэг байгуулсан тухай тогтоолыг хүлээн авч, election.gazar.mn системд хэсгийн мэдээлэл, нутаг, дэвсгэр, санал авах байрны мэдээллийг оруулж хуулийн хугацаанд бүртгэсэн.

2. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл УИХ-ын сонгуультай холбогдуулан 2024 оны 04 дугаар сарын 26-ны өдөр зогсохтой холбогдуулан 2024 оны 1 дүгээр сарын 1-ээс шилжилт хөдөлгөөн зогсох хүртлэх хугацааны 16-аас дээш насны 432 иргэн, 0-15 насны 277 иргэний нотлох баримтыг тухай бүр цахимжуулсан эсэх, бүртгэлийн үнэн зөвийг нягтлан шалгаж шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хаасан болно. Мөн Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24,2 хэсэгт заасныг үндэслэн “Иргэний шилжилт хөдөлгөөнийг зогсоох тухай” /2024 оны 08-р сарын 12 ны өдрөөс эхлэн сонгуулийн санал авах өдрийг дуустал хугацаагаар түр зогсоох тухай Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 07 ны А/128/ тушаалыг хэрэгжүүлж ажиллаа.

3. Аймгийн хэмжээнд УИХ-ын сонгуулиар 65, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулиар 67 хэсэг болж өөрчлөгдсөн. Тус аймгийн Түмэнцогт сум нь УИХ-ын сонгуулиар 4 баг нь 2 хэсэг болж байсан бол орон нутгийн сонгуулиар 4 баг тус тусдаа хэсэг болсон тул 67 хэсэгтэйгээр сонгууль явагдсан. Хэсгийн 6294 хаяг бүртгэгдсэн бөгөөд үүнээс аймгийн төв Баруун-урт суманд 9 багийн 5049, бусад 12 сумдад 1245 хаягийн мэдээллэл бүрэн орж, мэдээллийн санд буюу санал авах байранд бүртгэгдээгүй хаягийн жагсаалтанд хаяг орхигдоогүй, бүх мэдээллийг ИТХ-ын тогтоолтой тулган шалгаж, баталгаажуулж дуусгасан болно. Орон нутгийн сонгуулиар Баяндэлгэр сумын /15-3-6/, Сүхбаатар сумын /15-8-1/, Уулбаян сумын /15-11-1/ хэсэгт санал хураалт тэнцсэн тул 2024 оны 10 дугаар сарын 13 ны нэмэлт сонгуулийг зохион байгуулж ажиллаа.

4. Burtgel.gov.mn сайтаар дамжуулан таны байнга оршин сууж байгаа хаяг дээр амьдарч буй иргэдийн мэдээлэл шалгах хэсгээс ирүүлсэн 10 иргэний гомдолыг холбогдох иргэдтэй утсаар ярьж, зөвлөмж чиглэл өгсөн. Илтгэх хуудсыг тогтоосон хугацаанд Иргэний бүртгэлийн газарт хүргүүлсэн болно.

2024 оны УИХ-ын ээлжит сонгуулийн жилтэй холбогдуулан мэдээллийг санг цэгцлэх ажлын хүрээнд

1. Мэдээллийн санд нас баралтын бүртгэл давхар бүртгэгдсэн 202 иргэн
2. Ургийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, төрсөн он сар өдөр ижил 90 иргэн
3. Сонгогчийн нэрсийн жагсаалтад гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон 854 иргэний мэдээллийг нягтлан шалгах ажлууд хийгдсэн байна.

Нас баралтын бүртгэл 2 ба түүнээс дээш бүртгэгдсэн 202 иргэний мэдээллийг улсын бүртгэлийн мэдээллийн сан болон цаасан болон цахим архивт нягтлан шалгаж жагсаалтын ар талд дэлгэрэнгүй тайлбар бичиж хяналтын улсын байцаагчид шилжүүлсэн. Хяналтын улсын байцаагч нягтлан шалгаж улсын байцаагчийн 2024/406 тоот дүгнэлтийг гаргуулж шийдвэрлэсэн болно.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд төрсөн он сар өдөр эцэг, эхийн нэр, өөрийн нэр ижил 90 иргэний мэдээлэл ирсэнээс мэдээллийн сан болон цаасан архивтэй нягтлан тулган шалгаж, зарим иргэдтэй утсаар холбогдож шаардлагатай арга хэмжээг авч ажиллаа. Үүнтэй холбогдуулан нийт 90 иргэний бүртгэлээс 15 иргэний регистрийн дугаарыг хүчингүй болгох хяналтын улсын байцаагчийн 628 тоот дүгнэлтээр илэрсэн зөрчилийг арилгаж ажиллаа.

СНЖ-д гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон иргэдийн мэдээллийг аймгийн төвийн 9 баг, 12 сумын багийн дарга нартай хамтран 854

иргэний мэдээллийг гадаадад болон монголд байгаа эсэхийг лавлаж, иргэний улсын бүртгэлийн бүртгэгч нар өөрийн харъяа сумын иргэдтэй утсаар холбогдож, иргэний өргөдөлийг авч СНЖ-д төлөв өөрчлөх мэдээллийг бүртгэх ажлыг зохион байгууллаа.

Сонгуулийн хуулийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний дагуу хийгдэж байгаа ажлуудын талаарх илтгэх хуудасыг тухай бүр УБЕГ-т тайлагнав.

Тоон гарын үсгийн олголт 20824 иргэнд буюу аймгийн 16-аас дээш насны нийт иргэдийн 47,29 хувь нь хамрагаад байна.

Иргэний бүртгэлийн улсын ахлах бүртгэгч нарт нөхөн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн эрх олгосон хугацаанд 0-16 насны хүүхдийн төрсний бүртгэлд нийт 86 иргэний мэдээлэлд нэмэлт өөрчлөлтийн бүртгэл, нөхөн бүртгэл 32, Иргэний бүртгэлийн газраас нийт 26 удаагийн иргэний улсын бүртгэлтэй холбоотой зөвлөмж чиглэл ирснийг хэлтсийн болон сумдын бүртгэгч нарт дотоод группээр дамжуулан түргэн шуурхай хүргэж, ажилдаа мөрдлөг болгон ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа сар бүрийн 27-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн УБЕГ-ын Улсын бүртгэгч Ж.Нарантуяад j.narantuya@burtgel.gov.mn хаягаар, иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааны мэдээг сар бүрийн 26-ны өдөр 13 сум, хэлтсийн улсын бүртгэгч нарын хэмжээнд нэгтгэн Иргэний бүртгэлийн нэгдсэн архивын ахлах мэргэжилтэн Я.Мөнхтулга ya.munkhtulga@burtgel.gov.mn хаягаар мөн Иргэний бүртгэлийн тасгийн сар бүрийн тайланг p.enkhnar@burtgel.gov.mn хаягаар тус тус хүргүүлэн ажиллаж байна.

2024 онд иргэний бүртгэлийн чиглэлээр тоон мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэвэл:

Төрсний бүртгэлд 980 хүүхэд бүртгүүлснээс 499 нь эрэгтэй, 481 нь эмэгтэй,

Гэрлэлтийн бүртгэл 147

Гэрлэлт дуусгавар болсоны бүртгэл 39 бүртгэгдсэнээс захирааны журмаар 3, шүүхийн журмаар 36

Монгол улсын иргэнд хүүхэд үрчлэлтийн бүртгэл 18

Эцэг тогтоолтын бүртгэл 45

Ургийн овог, эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэрээ сольсоны бүртгэл 40

Нас барсны бүртгэл 327

16 нас хүрч иргэний үнэмлэхээ захиалсан бүртгэл 844

Иргэний үнэмлэхний дахин олголт 233

Иргэний үнэмлэхний 25,45 насны сунгалт 1355

Үндэсний энгийн гадаад паспорт захиалга 3583

БНХАУ-д зорчих нэг удаагийн үнэмлэх олголт 35

БНХАУ-д зорчих олон удаагийн үнэмлэх олголт 308

Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 1293

Регистерийн дугаарын өөчлөлтийн бүртгэл 6

Аймаг доторх шилжилт хөдөлгөөн 833

Иргэний бүртгэлийн чиглэлээр олгосон лавлагааг нэгтгэвэл :

Албан хэрэгцээнд 3501

Хууль хяналтын байгууллагад 583

Иргэнд 4984

Төрийн болон төрийн бусад байгууллагад өгсөн лавлагаа 0

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хагас жилийн байдлаар 5227 бүртгэлийн 19352 хуудас бүхий нотлох баримт цахимжаад байна. Үүнээс төрсний бүртгэл 2497, иргэний үнэмлэхний иуб-31 бүртгэл 3380, гадаад паспорт 3583 гэх мэт бүртгэлүүд дийлэх цахимжуулалтыг эзлэж байна.

Дэлхийн гэр бүлийн өдрийг тохиолуулан аймгийн Хүүхэд гэр бүл хөгжлийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран 8 хосд гэрлэлтийн гэрчилгээ гардуулах арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газараас гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаан дээр үндэслэж 81 иргэнийг гэрт нь очиж биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийг бүртгэсэн.

АРАВ. САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭЭР

Төсөв:

2024 оны 1-11 дүгээр сарын төсвийн санхүүжилтээр 1,018,4 сая төгрөгийн санхүүжилт орж ирсэн бөгөөд бүртгэлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад албан хаагчдын цалин, нэмэгдэл, хоол унааны зардалд 699,4 сая төгрөгийг, НДШ-ийн

зардалд 110,2 сая төгрөг, Байр ашиглалтын зардалд 19,8 сая төгрөг, Хангамж бараа материалын зардалд 12,7 сая төгрөг, Бусад зардалд 8,0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн хэмнэлт 27,2 сая төгрөг байна.

Төрийн захиргааны албан хаагчдын 5 жил тутамд олгох мөнгөн тэтгэмжид 140,6 сая төгрөгийг олгоод байна.

Тус хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд 2024 оны УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажлыг хангах 70,3 сая төгрөг орж ирсэнээс 70,3 сая төгрөгийг батлагдсан төсөв төлөвлөгөөний дагуу зарцуулаад байна. Мөн АНСДИТХ-ын сонгуультай холбогдуулан 64,8 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд 64,8 сая төгрөгийг зохих зардлуудад зарцуулан ажиллажээ.

Тус санхүүжилт нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэхэд шаардагдах бичгийн цаас, принтерийн хор, хавтас, дугтуй, сонгогчдын нэрсийн жагсаалтыг хэсгийн хороодод хүргэх шатахууны зардалыг зэрэгт зарцуулагдсан байна.

2024 оны 1-10-р сарын байдлаар тус хэлтэс нь улсын төсөвт бүртгэлийн үйл ажиллагаанаас олсон 96,6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан байна.

2024 оны 04-р сарын 17-19-ний өдрүүдэд МУ-ын хууль зүйн дотоод хэргийн яамнаас яамны харьяа байгууллагуудын Санхүүгийн нэгдсэн нэг программыг хэрэгжүүлэх үүднээс “Эрин системс” ХХК-ы санхүүгийн E-accounting программ нэвтрүүлэх сургалтанд суусан.

Санхүү, Аудитын чиглэлээр

Аймгийн мэргэжилийн хяналтын байр, газар нь тус хэлтсийн балансад ЗГ-ын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 109 дүгээр тогтоолоор шилжин ирсэн бөгөөд газрыг өөрийн нэр дээр шилжүүлэх аймгийн төрийн аудитын газрын зөвлөмжийг ханган ажиллаж байна. Газартай хобоотой материалыг аймгийн ГХБХБГазарт бүрдүүлэн өгч ажилласанаар аймгийн ЗД-ын 2024 оны 06 сарын 18-ны өдрийн А/134 тоот захирамжаар байгууллагын нэр дээр 15 жил эзэмших эрхийн гэрчилгээ олгогдсоноор Төрийн аудитын газраас ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийг 100% ханган ажиллаа.

Шилэн данс:

2024 онд Улсын бүртгэлийн хэлтэс нь МУ-ын шилэн дансны нэгдсэн сайтад 171 мэдээлэлийг байршуулах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа бөгөөд шилэн дансанд байршуулавал зохих мэдээлэлийг хуулийн хугацаанд, цаг алдалгүй тухай бүр байршуулж хэвшсэн байна.

2024 оны 11-р сарын 15-ны байдлаар 146 мэдээлэлийг хуулийн хугацаанд үнэн зөв байршуулсан бөгөөд үүнээс 25 мэдээлэлийн хуулийн хугацаа хүлээгдэж байна.

Хугацаа хоцорсон болон байршуулаагүй мэдээлэл байхгүй.

2023 онд УБХэлтэс нь шилэн дансны мэдээлэлийг 100% байршуулан ажиллсан.

Хүний нөөцийн чиглэлээр:

2024 оныг Хүний нөөцийг чадавхижуулах жил болгон зарласантай холбоотой тус хэлтэст хүний нөөцийг бүрдүүлэх ажлын төлөвлөгөө гарган Хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна.

2024 онд Хүний нөөцийн системд гэрээт 2 албан хаагч өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, 2 албан хаагч шинээр нэмэгдсэн .

Тухайн онд зэрэг дэвийн нэмэгдэл, Унаа хоолны нэмэгдэл, аймгаас Орон нутгийн нэмэгдэл сар бүр 10% эдгээр нэмэгдлийг цаг тухай бүр хүний нөөцийн системд бүртгэн албан хаагч нарт олгож байна.

МУЗГ-ын тогтоолоор үндсэн цалингийн шинэчлэлтийг хийсэн.


Таван жилийн тэтгэмж урамшуулалттай холбоотой албан хаагчдын нийт ажиллсан жил болон бусад мэдээлэлийг нарийн судалж хүний нөөцийн системд бүртгэн оруулаад байна.

АРВАН НЭГ. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Сүхбаатар аймгийн УБХ-ийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дотоод сүлжээ, интернэт сүлжээ, бүх албан хаагчид, сумдын бүртгэгч нарын компьютер, принтер, каноны хэвийн үйл ажиллагаанд байнгын бэлэн байдалыг ханган тухай бүрт нь засаж сэлбэн, шинээр сольж ажиллаж байна. Улиралд 1 удаа хэлтсийн албан хаагчдын суурин болон зөөврийн компьютеруудын тоос тоосонцорыг цэвэрлэн ажиллаж байна. 2024 оны байдлаар хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 26 удаа засвар үйлчилгээг хийсэн. Ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын зүгээс программ хангамж болон техник хангамжийн шинэчлэл, сайжруулалтын ажлыг байнга хийдэг бөгөөд “Улсын бүртгэлийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх төсөл”-ийн хүрээнд бүртгэлийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, анхан шатны нэгжүүдийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх зэрэг ажлуудыг тогтмол хийдэг. БНСУ-ын олон

улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар аймгийн 13 сумын улсын бүртгэгч нарт компьютер 13 ширхэг, 3 үйлдэлт принтер 13 ширхэг, хурууны хээ уншигч 13 ширхэг, зургийн аппарат 13 ширхэг зэрэг тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилсэн бөгөөд тус бүрийн тоног төхөрөмжийн системийн хэвийн үйл ажиллагааг ханган программ хангамж зэргийг бүрэн суулган ажиллах нөхцөлийн бүрдүүлэн ажиллаж байна.



Зураг 1. Бүртгэлийн үйл ажиллагааг хивийн үзүүлж буй байдал

Хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа болон УБЕГазраас зохион байгуулсан мэдээ мэдээлэл, санхүү хүний нөөц, сар бүрийн тоон мэдээлэл, өргөдөл гомдлын мэдээлэл, имфографик мэдээлэл, видео мэдээ зэргийг цаг тухай бүрт нь www.sukhbaatar.burtgel.gov.mn www.facebook.com/suburtgel гэсэн цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна.

Тус хэлтэс нь 2023.05.01 өдрөөс эхлэн хуучин Мэргэжлийн хяналтын газрын байранд шилжин нүүн орсонтой холбогдуулан хэлтсийн дотоод сүлжээг Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК, интэрнэтийн UNIVISION LLC сүлжээ тасалдалгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Хэлтсийн ажилтан албан хаагчидын дотоод сүлжээ болон интернэтийн сүлжээг шинээр татан ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. Хэлтсийн дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд илүү ашиглах шаардлагагүй сүлжээний кабел утасыг эмх цэгцтэй болгож шинээр ил гарсан утсуудыг бүрэн далдалсан. Сүхбаатар аймгийн 13 сум, хэлтсийн хэмжээнд бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагаа бүрэн хэвийн ажиллаж байна.

Сүхбаатар аймаг эрчим хүчний эх үүсвэрийн хувьд төвийн бүсийн эрчим хүч Багануур дүүргээс болон Дорнод бүсийн эрчим хүч ТӨК Дорнод аймгаас харъяалалтай байдаг бөгөөд өдөр бүр 2-3 удаа тог тасарч 13 сумын шилэн кабел болон тоног төхөөрөмж байнга шатаж байдаг. 2024 онд сумын рүүтер гэмтэж шатсанаас 1 сумын рүүтерийн тэжээлийн залгуурыг шинээр сольсон.

2019-2024 онд 13 сумын шилэн кабелийн медиа конвертерын тэжээлийн залгуур шатсаныг шинээр сольж хэвийн үйл ажиллагаанд оруулсан. Мөн 13 сумын хэмжээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

2024 оны УИХ, болон АНСДИТХ-ын сонгуулийн 67 хэсгийн хороонд ажиллах итгэмжлэгдсэн ажилтаны тоног төхөөрөмжийн тохиргоог сонгуулийн болон сургалтын өдөр хийж хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.



Зураг 2. Итгэмжлэгдсэн ажилтаны сургалт

Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн байранд 24/7 цахим үйлчилгээний төвийг 2024.02.06 өдөр нээж иргэдэд цагийн хязгаарлалтгүйгээр улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломжтой болгос



Зураг 3. 24/7 үйлчилгээний хэсэг

